

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ

ХОРООНЫ ТОГТООЛ

2009 оны 3 дугаар
сарын 26-ны өдөр

Дугаар 45

Улаанбаатар хот

“Прайм женерал даатгал” ХХК-д санхүүгийн даатгалын
хэлбэрээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл
нэмж олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Даатгалын тухай хуулийн 13.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Прайм женерал даатгал” ХХК-д санхүүгийн даатгалын (1.11) хэлбэрээр ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг нэмж олгосугай.

2. Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Даатгалын газар /С. Ганболд/, “Прайм женерал даатгал” ХХК-ийн ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад энэ тогтоолын 1 дэх хэсэгт заасан даатгалын хэлбэрийг нэмж бүртгэхийг Тамгын газар /Н. Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д. БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ